



## “ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар  
Сарын 13-ны өдөр

Дугаар ТУ32025-03/03

Улаанбаатар  
хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.10, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 28-р тогтоол, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ НЬ:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хуримтлагдсан ашиг нийт 1,274,651,690.98 /нэг тэрбум хоёр зуун далан дөрвөн сая зургаан зуун тавин нэгэн мянга зургаан зуун ерэн төгрөг ерэн найман мөнгө/ төгрөгт хүрсэн болохыг дурдсугай.
2. 2024 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 4,140 /дөрвөн мянга нэг зуун дөчин/ төгрөгөөр тооцож нийт 270,598,680 /хоёр зуун далан сая таван зуун ерэн найман мянга зургаан зуун наян/ төгрөгийг хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг болгон мөнгөн хэлбэрээр хуваарилахыг зөвшөөрсүгэй.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу албан татварыг суутган тооцож “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигч нарт 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор тараасугай.
5. Энэхүү тогтоолд заасан ногдол ашгийг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид арилжааны банк дахь дансанд шилжүүлж авахаар бичгээр хүсэлт гаргаж ногдол ашгийг авах боломжтойг дурдсугай.
6. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Ц.Отгонбаяр), Ахлах нягтлан бодогч (Ч.Мөнхзул) нарт үүрэг болгосугай.
7. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ногдол ашиг хуваарилах болсон тухай шийдвэр, шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн дараагийн зарлагдах хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Отгонбаяр), Ахлах нягтлан бодогч (Ч.Мөнхзул) нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Ц.БААТАРСАЙХАН

